

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/07/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай хот
2022 он

Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дагвасүрэн
Утас: 99014227
Цахим хаяг: daqvasurend@audit.gov.mn

Аудитор: Г.Баасанжаргал
Утас: 99032514
Цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.2.1 Залруулсан алдаа	12
4.2.2 Төлбөрийн акт	12
4.2.3 Албан шаардлага	12
4.2.4 Зөвлөмж.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2022.02.24 № 1302/252
танай _____ -ны № _____ -т

БЯАНХАЙРХАН СУМЫН
ЗДТГ-н ДАРГА Х.ОЮУНЧИМЭГ-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхайрхан сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхайрхан сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013325219

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3602828.97	10736066.00
33	АВЛАГА	175000.00	175000.00
335	Бусад авлага	175000.00	175000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	175000.00	175000.00
34	УРЬДЧИЛГАА	400000.00	0.00
3471	Урьдчилгаа тооцоо	400000.00	0.00
34713	Цалингийн урьдчилгаа	400000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3027828.97	10561066.00
351	Түүхий эд материал	926968.97	2099519.00
35110	Тусгай зориулалттай материал	926968.97	2099519.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0.00	112000.00
354	Хангамжийн материал	2100860.00	8349547.00
35410	Бичиг хэргийн материал	295260.00	1129600.00
35420	Аж ахуйн материал	0.00	536100.00
35440	Түлш, шатах тослох материал	1805600.00	2900847.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	3783000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	489544362.79	421366963.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	489544362.79	421366963.84
391	Газар	5908000.00	5908000.00
392	Биет хөрөнгө	481386362.79	413359780.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	241379151.56	218785990.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-43331539.12	-38104859.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	124604800.00	80414800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-94826880.73	-62008339.77
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184889900.40	58416641.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-152277421.62	-33332237.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17928377.00	12172155.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14188948.43	-9949718.77
39209	Зам, гүүрийн байгууламж	9179103.00	9179103.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-3442163.40	-3901118.52
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3660000.00	3660000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	344065396.00	323495396.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-137784111.87	-146998731.14
39217	Ном	1530700.00	1530700.00
393	Биет бус хөрөнгө	2250000.00	2099183.16
39301	Програм хангамж	3552000.00	3552000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1302000.00	-1452816.84
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	493147191.76	432103029.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	168049.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	168049.00	0.00
413	Өглөг	168049.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	150049.00	0.00
4136	Бусад өглөг	18000.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	18000.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	492979142.76	432103029.84
51	Засгийн газрын хувь оролцоо	492979142.76	432103029.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	279825085.40	279825085.40
51101	Өмч: - төрийн	279825085.40	279825085.40
512	Хуримтлагдсан үр дүн	41531492.11	-19344620.81
51210	Өмнөх үеийн үр дүн	41531492.11	41531492.11
51220	Тайланг үеийн үр дүн	0.00	-60876112.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	171622565.25	171622565.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	493147191.76	432103029.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	328171743.00	342261726.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9635520.00	14192947.00
120	Нийтлэг татварын бус орлого	9635520.00	14192947.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9635520.00	14140447.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9635520.00	14140447.00
120009	Бусад орлого	0.00	52500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	318536223.00	328068779.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	318536223.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	318536223.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	48290979.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	48290979.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	279777800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	276077800.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	0.00	2500000.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	0.00	1200000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	412230634.45	383579536.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412230634.45	383579536.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397007497.51	343894690.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	197718911.00	198648273.00
210101	Үндсэн цалин	197718911.00	192794061.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	5854212.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25964552.00	25636032.12
210201	Тэтгэврийн даатгал	17755564.00	17822655.68
210202	Тэтгэмжийн даатгал	2112097.00	1978234.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	1625837.00	1552350.04
210204	Ажилгүйдлийн даатгал	406459.00	383059.66
210205	Эрүүд мэндийн даатгал	4064595.00	3899732.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10380107.00	5620926.99
210301	Гэрэл, цахилгаан	1504947.00	1180926.99
210302	Түлш, халаалт	8875160.00	4440000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25661611.00	20905210.00
210401	Бичиг хэрэг	4960240.00	2280960.00
210402	Тээвэр, шатахуун	17010029.00	17324170.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2828642.00	1251080.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	862700.00	49000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20353460.00	5814900.00
210604	Урсгал засвар	20353460.00	5814900.00
2107	Томилголт, зочны зардал	5068000.00	3581000.00
210702	Дотоод албан томилголт	5068000.00	3581000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6757360.00	3514098.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5315196.00	2175458.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432000.00	482100.00
210803	Даатгалын үйлчилгээ	213950.00	469100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	340675.00	88500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66000.00	66000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300000.00	203400.00
210807	Газрын төлбөр	89539.00	29540.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105103496.51	80174250.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38861725.00	15475154.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18800.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66222971.51	64699096.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15223136.94	39684845.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	11691200.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11691200.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3531936.94	39684845.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3531936.94	39684845.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-84058891.45	-41317810.07
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	19558302.85
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	19558302.85
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-19558302.85
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-84058891.45	-60876112.92

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	279,825,085.40	171,622,565.25	125,196,556.34	0.00	576,644,206.99
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	279,825,085.40	171,622,565.25	125,196,556.34	0.00	576,644,206.99
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	279,825,085.40	171,622,565.25	125,196,556.34	0.00	576,644,206.99
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	279,825,085.40	171,622,565.25	125,196,556.34	0.00	576,644,206.99
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	279,825,085.40	171,622,565.25	41,137,664.83	0.00	492,585,315.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	279,825,085.40	171,622,565.25	41,531,492.11	0.00	492,979,142.76
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	-60,876,112.92	0.00	-60,876,112.92
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	279,825,085.40	171,622,565.25	-19,344,620.81	0.00	432,103,029.84

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	318536223.00	328121279.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	52500.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	52500.00
120009	Бусад орлого	0.00	52500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	318536223.00	328068779.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	318536223.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	318536223.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	48290979.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	48290979.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	279777800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	276077800.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	0.00	2500000.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	0.00	1200000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	301266373.00	322091279.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	301266373.00	322091279.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	286043236.06	282406433.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	196990928.00	196756154.12
210101	Үндсэн цалин	193316880.00	181764120.12
210105	Гэрээт ажлын хөлс	3674048.00	14992034.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27096200.00	27278200.00
210201	Тэтгэврийн даатгал	18898100.00	19195800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1978900.00	2020600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1591300.00	1616400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	640300.00	404200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3987600.00	4041200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8642647.06	8086926.99
210301	Гэрэл, цахилгаан	1805647.06	1246926.99
210302	Түлш, халаалт	6837000.00	6840000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18426071.00	19543480.00
210401	Бичиг хэрэг	2886900.00	2821100.00
210402	Тээвэр, шатахуун	12709229.00	15463300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2829942.00	1259080.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3314900.00	5814900.00
210604	Урсгал засвар	3314900.00	5814900.00
2107	Томилолт, зочны зардал	4583000.00	3581000.00
210702	Дотоод албан томилолт	4583000.00	3581000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7456960.00	4364815.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6014796.00	3026175.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432000.00	482100.00
210803	Даатгалын үйлчилгээ	213950.00	469100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	340675.00	88500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66000.00	66000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300000.00	203400.00
210807	Газрын төлбөр	89539.00	29540.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19532530.00	16980957.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19230000.00	16979757.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	302530.00	1200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15223136.94	39684845.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	11691200.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11691200.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3531936.94	39684845.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3531936.94	39684845.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17269850.00	6030000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17269850.00	6030000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17269850.00	6030000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17269850.00	6030000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17269850.00	6030000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-17269850.00	-6030000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	353551800.00	292608237.12	279777800.00	270703001.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	353551800.00	292608237.12	279777800.00	270703001.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	341860600.00	280917037.12	279777800.00	270703001.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239046700.00	196990928.00	203382100.00	196756154.12
210101	Үндсэн цалин	223272700.00	181724260.00	186930800.00	181764120.12
210105	Гэрээт ажлын хөлс	15774000.00	15266668.00	16451300.00	14992034.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34345100.00	27096200.00	27456500.00	27278200.00
210201	Тэтгэврийн даатгал	23970700.00	18898100.00	19321300.00	19195800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2523100.00	1978900.00	2033800.00	2020600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2018500.00	1591300.00	1627000.00	1616400.00
210204	Ажигүйдлийн даатгал	786400.00	640300.00	406800.00	404200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5046400.00	3987600.00	4067600.00	4041200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9127700.00	3811294.12	8927700.00	8086926.99
210301	Гэрэл, цахилгаан	2087700.00	1805647.06	2087700.00	1246926.99
210302	Түшл, халаалт	7040000.00	2005647.06	6840000.00	6840000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20536100.00	19026071.00	19673000.00	19644580.00
210401	Бичиг хэрэг	3288800.00	2886900.00	2922200.00	2922200.00
210402	Тээвэр, шатахуун	13702300.00	12709229.00	15463300.00	15463300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3545000.00	3429942.00	1287500.00	1259080.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16708500.00	16314850.00	5814900.00	5814900.00
210602	Тавилга	13000000.00	12999950.00	0.00	0.00
210604	Урсгал засвар	3708500.00	3314900.00	5814900.00	5814900.00
2107	Томилолт, зочны зардал	4583000.00	4583000.00	4210100.00	3581000.00
210701	Гадаад албан томилолт	539900.00	539900.00	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	4043100.00	4043100.00	4210100.00	3581000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10410100.00	6562264.00	4510100.00	3738640.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6500000.00	3470100.00	2400000.00	2400000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	482100.00	432000.00	482100.00	482100.00
210803	Даатгалын үйлчилгээ	469100.00	213950.00	469100.00	469100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	727700.00	340675.00	727700.00	88500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73800.00	66000.00	73800.00	66000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2003400.00	1950000.00	203400.00	203400.00
210807	Газрын төлбөр	138300.00	89539.00	138300.00	295400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15700.00	0.00	15700.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7103400.00	6532430.00	5803400.00	5802600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6800000.00	6229900.00	5500000.00	5500000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303400.00	302530.00	303400.00	302600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11691200.00	11691200.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11691200.00	11691200.00	0.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11691200.00	11691200.00	0.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20891200.00	21691200.00	279777800.00	270650501.11
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20891200.00	21691200.00	279777800.00	270650501.11
122005	Орон нутгийн төсвөөс	20891200.00	21691200.00	279777800.00	270650501.11
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	21.00	20.00	21.00	20.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	0.00	1.00	0.00
610001	Төсвийн байгууллага	1.00	0.00	1.00	0.00
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.00	20.00	20.00	20.00
620001	Удирдах ажилтан	7.00	7.00	7.00	7.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	2.00	2.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00	3.00	3.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	17733432.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	17733432.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	17733432.04
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	673675.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	673,675.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	17059757.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	17,059,757.04
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	17733432.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	17733432.04
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	17,733,432.04

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах төрийн байгууллага, мэргэжилтэн, албан хаагч багийн Засаг дарга нарын ажлыг уялдуулан оновчтой бодлого, зохицуулалтаар хангаж орон нутгийн хөгжлийн төлөө төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэж, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд чиглэгдэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 342,261.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,281.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 2,133.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	575.00	175.00	(400.00)
Бараа материал	3,027.80	10,561.10	7,533.30
Үндсэн хөрөнгө	489,544.30	421,366.90	(68,177.40)
Нийт хөрөнгө	493,147.10	432,103.00	(61,044.10)
Өр төлбөр	168.00	-	(168.00)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	492,979.10	432,103.00	(60,876.10)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	493,147.10	432,103.00	(61,044.10)

Авлага дансны үлдэгдэл 400.0 мянган төгрөгөөр буурсан нь цалингийн урьдчилгаа авлага тайлант онд барагдсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 7,533.3 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан материал, аж ахуй болон засварын материалын худалдан авалт их байсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 68,177.4 мянган төгрөгөөр буурсан тайлант онд акталсан хөрөнгөтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 168.0 мянган төгрөг болж буурсан нь тайлант онд өмнөх оны өглөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 60,876.1 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 279,777.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 279,777.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 279,777.8 мянган төгрөг, нэмэлт дансаар 48,290.9 мянган төгрөг, татварыг бус орлого 52.5 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 322,091.2 мянган төгрөгийг зарцуулж, 9,127,3 мянган төгрөгийг улсын төсөвт, 30,557.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансны гүйцэтгэлд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 673.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 17,059.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн анхан шатны баримтын бүрдүүлэлт сайн, Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цагалбар, болон НББ-ийн тухай хууль, Сангийн сайдын 388 дугаар тушаалын дагуу бэлтгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Төсвийн тухай хууль болон НББ-ийн тухай хууль бусад заавар журмыг дагаж мөрдсөн байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 41,334.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 39,684.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 0.00 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.00 төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,650.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлангаас төвлөрүүлэх шилжүүлгийг цэвэрлэж тайлагнаагүй 39,684.8 мянган төгрөгийн алдааг залруулсан.

4.2.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.2.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Төсвийн аривлан хэмнэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

2020 онд нийлүүлэгдсэн “Си-Ту-Эс” ХХК-аас 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн програмыг одоог хүртэл ашиглаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, УСНББОУС 17-той нийцэхгүй бөгөөд тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

“Си-Ту-Эс” ХХК-аас худалдан авсан 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн програмыг 2022 оны 03 дугаар сарын 01-ээс ашиглаж эхлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян.төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
		2	41,334.8	1	39,684.8					1	1,650.0
	Дүн	2	41,334.8	1	39,684.8					1	1,650.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Дүн										
	Нийт дүн										

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА 2022.02.25

АХЛАХ АУДИТОР Б.ДАГВАСҮРЭН 2022.02.25

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Г.БААСАНЖАРГАЛ 2022.02.25